



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2010 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Төлөөлөгчдийн бүрэлдэхүүн батлах тухай

Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо болох НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Ажлын хэсгийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи Үндэсний илтгэл, Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 45 дугаар чуулганаар Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэлийг хамгаалах Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийг дараахь бүрэлдэхүүнтэй баталсугай:

- Төлөөлөгчдийн тэргүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар;
- Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх салбар болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Л.Оргил;
- Улсын ерөнхий прокурорын туслах, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Б.Бат-Орших;
- Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх хэлтсийн дарга С.Болдбаатар;
- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын албаны дарга Л.Мөнхцэцэг;
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга Ш.Отгонхундага;
- Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ч.Баттөмөр;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Ж.Соёмбо;

-Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын
атгаше Э.Батзориг;

-Орчуулагч Д.Халиун.



Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД